



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 8/37

Чингис хот

С.Оюун-Эрдэнийг ажлаас түр чөлөөлж,
ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 44.3, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал, байгууллагын өргөдөл гомдол, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Сумъяагийн Оюун-Эрдэнийг ажлын зайлшгүй шаардлагын улмаас тус хэлтсийн Хүний нөөц, агентлаг хариуцсан ахлах мэргэжилтнээр шилжүүлэн ажиллуулах болсон тул 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. С.Оюун-эрдэнийг Хүний нөөц, агентлаг хариуцсан ахлах мэргэжилтнээр 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

3. С.Оюун-Эрдэнийн цалинг ТЗ-6-5 шатлалаар тогтоон, үндсэн цалинг 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан таван мянга)-н төгрөгөөр, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 30 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 18 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг С.Оюун-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

